



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/13/-НА-СТА-УТҮГ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Алтай хот	Аудитын менежер: Утас: 70484055	Д.Эрдэнэчимэг Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
2022 он	Ахлах аудитор: Утас: 99177546	Ж.Бүжинханд Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn
	Аудитор: Утас: 99282488	С.Санчирмаа Цахим хаяг: Sanchirmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.15 № 172

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.ТҮВШИНБЯАР



07020458

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
3. Аудитын тайлан	5
3.1 Ерөнхий зүйл	5
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	6
3.8 Аудитын гол асуудал	6
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	6
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	6
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	7
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	7
4. Аудитын илрүүлэлт	7
4.2.1 Залруулсан алдаа	7
4.2.2 Төлбөрийн акт.....	7
4.2.3 Албан шаардлага	7
4.2.4 Зөвлөмж.....	7
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	8
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	8

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	29,237,540.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	26,000,305.23
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	26,000,305.23
3121	Төгрөг	-	26,000,305.23
31213	Арилжааны банк дахь харилцах	-	26,000,305.23
35	БАРАА МАТЕРИАЛ	-	3,237,235.00
351	Түүхий эд материал	-	305,000.00
35110	Тусгай зориулалттай материал	-	305,000.00
354	Хангамжийн материал	-	2,932,235.00
35410	Бичиг хэргийн материал	-	491,470.00
35420	Аж ахуйн материал	-	390,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	2,050,765.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	61,862,140.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	61,862,140.03
392	Биет хөрөнгө	-	44,335,473.38
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	30,380,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	3,544,333.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	12,668,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	485,659.83
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	5,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	183,333.34
393	Биет бус хөрөнгө	-	17,526,666.65
39301	Програм хангамж	-	19,120,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	1,593,333.35
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	91,099,680.26
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	91,099,680.26
51	Засгийн газрын хувь оролцоо	-	91,099,680.26
512	Хуримтлагдсан үр дүн	-	91,099,680.26
51220	Тайлант үеийн үр дүн	-	91,099,680.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	91,099,680.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		239,650,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		2,532,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		2,532,000.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		2,532,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		237,118,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		237,118,700.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/		237,118,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		148,551,019.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ		148,551,019.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		148,551,019.74
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		148,551,019.74
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/		15,646,449.67
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/		126,767,600.07
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/		5,841,970.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/		295,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		91,099,680.26
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		91,099,680.26

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	91,099,680.26	0.00	91,099,680.26
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	91,099,680.26	0.00	91,099,680.26

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)		239,650,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		2,532,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		2,532,000.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/		2,532,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		237,118,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		237,118,700.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/		237,118,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)		145,981,594.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ		145,981,594.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		145,981,594.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		91,115,440.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		91,115,440.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		27,834,156.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		27,834,156.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		2,500,000.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/		2,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		6,579,205.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/		6,579,205.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		17,952,793.77
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		7,818,005.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/		10,134,788.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		93,669,105.23
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		67,668,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		67,668,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр		67,668,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		67,668,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		- 67,668,800.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		26,000,305.23
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		26,000,305.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны		Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Санхүүгийн дэмжлэг	219,118,700.0	237,118,700.00	(18,000,000.0)	108%
Өөрийн орлого	3,000,000.0	2,532,000.00	468,000.0	84%
ОРЛОГО	222,118,700.0	239,650,700.0	(17,532,000.0)	
1.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг			-	0%
1.3 Нийт ашиг	222,118,700.00	239,650,700.00	- 17,532,000.00	108%
Үндсэн үйл ажиллагаа	216,782,000.0	148,256,019.74	68,525,980.3	68%
Бусад зардал	2,340,000.0	295,000.00	2,045,000.0	13%
1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн	219,122,000.00	148,551,019.74	70,570,980.26	68%
1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	2,996,700.00	91,099,680.26	- 88,102,980.26	3040%
Удирдлагын зардал	2,996,700.00		2,996,700.0	0%
3. Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	-	91,099,680.26	- 88,102,980.26	0%
Татвараас чөлөөлөгдөх зардал				
Татвар төлөх ашиг алдагдал	-	91,099,680.26	- 88,102,980.26	-
3.1 Орлогын татварын зардал			-	
4. Татварын дараах ашиг алдагдал	-	91,099,680.26	- 88,102,980.26	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	26,000.3	+26,000.3
БХХО	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	0	3,237.2	+3,237.2
Үндсэн хөрөнгө	0	61,862.4	+61,862.4
Биет бус хөрөнгө	0	17,526.7	+17,526.7
Нийт хөрөнгийн дүн	0	91,099.7	+91,099.7
Өр төлбөрийн дүн	0	0	0
Богино хугацаат өглөг	0	0	0
Урт хугацаат өглөг	0	0	0
Эздийн өмч	0	91,099.7	+91,099.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	0	91,099.7	+91,099.7

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлгүй. Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 26.0 сая төгрөг байна.

Авлага дансанд үлдэгдэлгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 3.2 сая төгрөг болсон. Тайлант онд худалдан авалтаар 6.6 сая төгрөгийн тусгай зориулалтын материал, бараа бэлэн бүтээгдэхүүн, бичиг хэргийн материал, аж ахуйн материал, түлш, шатах тослох материал, барилгын засварын материал, бусад хангамжийн материал нэмэгдсэн, 3.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгөнд шинээр 67.7 сая төгрөгийн тавилга, эд хогшил, машин тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө биет бус хөрөнгө худалдан авч нэмэгдсэн.

Богино хугацаат өр төлбөрийн дансанд үлдэгдэлгүй байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Тайлант онд шинээр үүсгэн байгуулагдсан ч ашигтай ажилласан байна.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төвийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 116 дугаар тогтоолоор “Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв” УТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 222.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 222.1 сая төгрөгөөр, ашиг /алдагдал/-гүй байхаар тогтоосон байна. Үүнээс төсвийн төлбөрт 50.2 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 239.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 148.5 сая төгрөгийн зардал гарган, 91.1 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 239.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 18.0 сая төгрөг буюу 8 хувиар тасарсан байгууллагын санхүүгийн дэмжлэг нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 148.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 70.6 сая төгрөг буюу 32 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь үндсэн үйл ажиллагааны гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 91.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 91.1 сая төгрөгөөр илүү байгаа нь зардлыг багассантай холбоотой байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Нэгдсэн эмнэлгийн 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, и-баримтыг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 24 мэдээллээс 1 төрлийн 5.1 сая төгрөгийн худалдан авалт, зарлагын гүйлгээг залруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шинээр үүсгэн байгуулагдсан тул завсрын аудит хийгдээгүй, өмнөх зөвлөмж байхгүй

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар:

- ✓ Бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах,
- ✓ төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй.

Ком-Алтай ХХК-аас нийлүүлсэн dell брэндийн 5 ширхэг 13 нөтбүүкийг техникийн тодорхойлолтоос бага үзүүлэлттэй нийлүүлсэн байна. Иймээс байгууллагын удирдлага техникийн тодорхойлолтоос зөрүүтэй нийлүүлсэн асуудлыг анхааралдаа аван шийдвэрлэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 239.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 239.6 сая төгрөгийн алдааг залруулж, 2 зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Үр дүнгийн тайланд 148.5 сая төгрөгийн залруулга хийсэн. Татварын тайланг 91.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залруулсан.

4.2.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

4.2.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төвийн захиралд:

1. Санхүүгийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж үйл ажиллагаандаа ашиглаагүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.", 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах"; гэж заасны дагуу холбогдох хууль эрх зүйн хүрээнд нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй болон мөрдөн ажиллах

Аймгийн Татварын хэлтэст:

2. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Нийт орлогын дүн 50 сая төгрөгөөс дээш байтал нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5-т "өрийн төлбөрийг бараа шилжүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх замаар

барагдуулсан бол үнийн дүнгээр" гэсэн заалтын дагуу холбогдох хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв	4	239.6	2	239.6					2	0
	Дүн	4	239.6	2	239.6					2	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв										
	Дүн										
	Нийт дүн	4	239.6	2	239.6					2	0